

Монголын төрийн сонгох уламжлалын
тухай асуудалд

Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Болдбаатар
Докторант Л.Ариунаа

Монголын төрийн сонгох уламжлалын язгуур эх нь ураг төрлийн байгуулалын задралын үеийн ард нийтийн хурлаас эхлэлтэй юм. Монгол нутаг дээр амьдарч байсан овог, аймгууд, өөрийнхөө толгойлогчийг сонгож байсан нь дэлхийн нийтийн жишигтэй адил бөлгөө.

Я.Цэвэл аругайн "Монгол хэлний товч тайлбар толь"-д: "Сонгох. 1.сайныг шилэх, хэрэгтэй ашигтайгийг нь шилж авах, олны дотроос сонгож авлаа, ном сонгож авах, мэргэшил сонгох; 2. олны саналаар баталж томилох, даргыг сонгох, улируулан сонгох, сонгох, сонгогдох эрх" (1.475) хэмээн тайлбарлажээ. Иймээс сонгох нь дороос сонгох, дээрээс шилж сонгох гэсэн хоёр талтай байна.

Монгол төрийн сонгох түүхэн уламжлалыг Бүгд найрамдах байгуулал тогтох хүртэл хэд хэдэн шатаар үечлэн үзэж болно. Үүнд:

1. Монголын эртний улсуудын төрийн сонгох ёс журам. МЭӨ-209 онд Хүннү нарын төр засгаа байгуулсан цадиг түүх нь монголын төр ёс, эрх зүйн хөгжлийн анхны үр хөврөл, улбаалан дэвжих хөрс дэвсгэр болж өгсөн юм. Анхны төр ёсыг үндэслэгч нь Маодунь шаньюй байлаа.

Маодунь шаньюйгийн угсаа гарвал нь сюйлянйи овог байв. Иймээс зөвхөн эл овгийн хүнийг, гэхдээ гол төлөв хан хөвгүүнийг Шаньюйгээр өргөмжлөн сонгож байсан нь Монголын эртний улсуудад сонгох ёсны зарим бүрдэл байсныг гэрчилнэ. Эл уламжлал нь Монголын эртний улсуудад ямар нэг хэмжээгээр уламжлагдаж байжээ.

XI-XII зууны Монголын ханлиг, аймгууд нь хан, толгойлогчоо өргөмжлөхдөө мөн л сонгох ёсны бүрдлийг ямар нэг хэмжээгээр хэрэглэж байсан юм. Тухайлбал, 1189 онд Тэмүжин Хамаг Монголын хаан сэнтийд суухдаа өргөмжлөх, сонгох ёсыг хослуулж байсан бөлгөө. Монголын эртний улсууд дахь сонгох ёсны мөн чанар нь ураг төрлийн байгуулалын үеийн сонгох ёсыг алтан ургийн хаан өргөмжлөх явдалтай нэгэн хамтад хэрэглэж байсанд оршино.

2. Их Монгол болон эзэнт гүрний үеийн төрийн сонгох ёс. (МЭ-XIII-XIV зуун). Энэ үеийн сонгох ёс нь их хааны Их Хуралдайгаар өргөмжлөн сонгох ёс тогтсон, Сэцийн зөвлөлийг шалгаруулан сонгож байснаар голлон тодорхойлогдоно. Тухайлбал, язгуур монголчуудыг нэгтгэх үлэмж их үйл хэргийг орь залуугаасаа 20 гаруй жил оройлон манлайлж, эр тавирсан 45 насандаа бодит биелэл болгосон Тэмүжинг шинэ тулгар Монгол улсын хаан ширээнд нэгэн дуугаар өргөмжлөн сонгосон явдал юм. Энэ тухай "Монголын нууц товчоо"-нд "...эсгий туургатан улс энх шударга болж, Барс жил Онон мөрний эхэнд хуралдаж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүжинд Чингис хаан (Далай хаан) цолыг өргөв. (2,164) хэмээжээ. Ер нь алтан ургийн хэн бугай ч Их хуралдайгаар өргөмжлөн сонгох зарчмыг алгасан хааны титэм хүртэх хууль зүйн болон ёс суртахууны эрхгүй байсанд гол учир байгаа юм.

Их Хуралдайн чөлөө завсарт үүдэн бий болсон тулгамдсан асуудлыг хэрхэн шийдэх талаар зөвлөдөг чухал байгууллага болох Сэцийн зөвлөлийн бүрэлдэхүүнд Эзэнт гүрний хэмжээнд сонгон шалгарсан мэргэдийг оруулж байсан бололтой. Энэ нь Монгол төрийн сонгох ёсны нэгэн өвөрмөц хэлбэр байсан гэж үзэж болохоор байна.

Хүн төрөлхтний түүхэнд монголчууд парламентат ёсны өвөг гэж хэлж болохоор Их Хуралдай, Сэцийн зөвлөл зэрэг нүүдэлчдийн ардчилалын өвөрмөц бүрдлүүдийг анх үүсгэн, дараа дараагийн үедээ өвлүүлсэн гэж хэлж болно.

3. Улс төрийн бутралын үеийн сонгох ёс. (XIV-XVII зуун). Энэ үед төрийн сонгох ёс тун бүдгэрч иржээ. Язгууртан дээдсийн түвшинд их хааныг дээдлэн, өргөмжлөн сонгох явдал суларч, ёс төдий болсон, доодос их хаанаас илүү өөрийн шууд харъяалсан ноёдыг аялдан дагалдах байдалтай болжээ.

4. Манжийн эрхшээлийн үеийн Монгол орон дахь сонгох ёс. (XVII-XX зууны эх). Энэ үед сонгох ёс төрийн гэсэн утгаараа бараг алга болсон. Харин монголын засаг ноёд өөрийгөө залгамжлах хүүгээ хөвгүүдийнхээ дотроос сонгож, Манжийн хаанд өргөн мэдүүлж, батламж зарлиг гаргуулж байсан юм. Үүнийг маш явцуу хүрээнд сонгох бичил бүрдэл байсан гэж үзэж болох юм.

5. Олноо өргөгдсөн Монгол улсын үеийн сонгох ёс. (1911-1919 он). 1911 оны үндэсний хувьсгалын үр дүнд Монголчууд тусгаар тогтнолоо дахин сэргээсэн. Дурьдан буй үед монголчуудын улс төрийн идэвхи сэргэж, төрийн сонгох, сонгогдох зарчмыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхийг эрмэлзэх болжээ. 1914 онд Улсын дээд, доод хурлыг сонгуулийн сонгодог тогтолцооны журмаар байгуулаагүй ч гэсэн хэргэм зэрэг, албан тушаалын зэрэглэлээр шилэн сонгож бүрдүүлсэн юм. Ялангуяа Дээд хурлыг байгуулах зарчим нь Английн парламентын Лордын танхимыг бүрдүүлэхтэй төстэй байжээ.

Олноо өргөгдсөн Монгол улсын үед төрийн албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах шалгуурыг нарийвчлан тогтоосон байна. "Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг"-т түшмэдийг сонгон шалгаруулахдаа чухам шалгах (эрдэм чадал, сахилга бат, ажил хэргийн байдал төлөв, нас) дөрвөн зүйл, түшмэл хүнийг нэр үл тэвчих 8 зүйлээр (ховдог, харгис, зөөлөн үхээнц, чадалгүй, хичээнгүй бус, өвчтэй, долгин хатан, эрдэм дорой) шалган хэлэлцэж, дэвшүүлж бууруулах асуудлыг шийдэж байжээ. (3,33)

Энэ үед "Шинэ толь", "Нийслэл Хүрээний сонин бичиг" зэрэг дэвшилт хэвлэлүүдэд Хөрөнгөтний Бүгд Найрамдах засаг, сонгож байгуулах засгийн тухай үзэл санааг дэвшүүлсэн өгүүлэлүүд нийтлэгдэх болжээ.

1913 онд "Шинэ толь" сэтгүүлийн нэгдүгээрт: "...хэрвээ улс төрийг ганцхан хүн өөрийн зоригор засах бөгөөс үүнийг хэмжээгүй эрхт төр гэнэ. Хэрвээ улсын дээд эрхийг албат нар олноор орж, зөвлөлдөн хэдэн хүнд тушааж, улсын хэрэг зөвлөн шийтгэх чуулган байгуулж, бас нэгэн хүнийг сонгож, улсын тамга байгуулж, хэдэн жилийн болзоогоор бүгд өрөнхийлөх эрх олгодог төрийг Бүгд Найрамдах Улс гэнэ. Хагасыг хаан, хагасыг албат ард бариваас хэмжээт цаазат улс хэмээмой" (4) гэж бичиж байв. Энэ нь Монголд анх удаа олон түмэнд Бүгд Найрамдах Засаг буюу сонгож байгуулах засгийн тухай сурталчилсан хэрэг байв. Харин "Монголын сонин бичиг" 1917 оны Орос дахь хэрэг явдлын тухай мэдээлэхдээ сонгох, сонгогдох ёсны асуудлыг илүү нарийн, энгийн ойлгомжтой өгүүлсэн байна. Тухайлбал: "Хуучин засгийн эрх баригчдын гэмээр улс төрийн хэрэг ихэд эвдэрсэн учир шинэ засаг байгуулан тогтов. Нэгэнт шинэ засаг байгуулахад олон нийтэд итгэмжлэгдсэн доорд хурлын төлөөлөгчдийг сонгон өргөмжилж, тэд нарт шинэ засгийн хэрэг шийтгэх төгөлдөр эрхийг тушаав" (5) гээд шинэ засгийн сайд нарын нэрийг жагсаажээ. Тэрхүү өгүүлэлд шинэ засгаас аливаа хүнд үг хэлэх, элдэв зүйлийн бичиг бичиж тараах, хурал цуглаан хийх, төрийн тухай хэрэг хэлэлцэхэд хүн бүр оролцох эрхтэй, шашин шүтэхийг сайн дур болгож байна хэмээн улс төрийн өргөн эрх олгосныг дурдсан байна. Улмаар төдхөн олны дундаас төлөөлөгчдийг сонгон, зөвлөлдөөн хурал байгуулж, төрийг "ард бүгдээр найрамдах улсын хууль дүрмээр явуулна" (6) гэж онцлон тэмдэглэсэн байна.

Олноо өргөгдсөн Монгол улсын дэвшилтэт үзэлтэй удирдах зүтгэлтнүүд ч Бүгд Найрамдах Засгийн үзэл санааг талархан хүлээж авч байжээ. Нийслэл Хүрээнд байсан Оросын консул Орлов Засгийн газартаа илгээсэн бичигтээ: Намнансүрэн, Цэрэндорж нарын ярианы тухай сонирхолтой өлгөцийг иш татжээ. Үүнд: "Цэрэндорж...бид монголын хувь заяаг тавуулхнаа шийдэж байдгаараа муу юм хийж байна гэж би Сайд нарын Зөвлөлд нэг бус удаа хэлж байсан юм. Биднийг алдаа гаргалаа гээд шийтгэлээ ч гэсэн улс ямар ашиг олох билээ гэж байна. Сайн ноён хан ийм их эргэлтийг өдий богино хугацаанд хийж чадсан Оросын ард түмэн нэгэн санаанд гаргасанд баяр хүргэе гэж үнэн санаанаасаа надад хэлж байна" (64) хэмээн тэмдэглэжээ.

1917 оны Оросын хувьсгалт эргэлтийн дараа "Нийслэл Хүрээний сонин бичиг" Бүгд Найрамдах Засаг, түүний сонгож байгуулах зарчим, мөн чанарын талаар бүр тодорхой тайлбарлах болжээ. Эл сониний 1917 оны X сарын 17-ны өдрийн дугаарт

"Республика-хэмээх Бүгд Найрамдах захиргаа" гэсэн хэмээх томоохон өгүүлэл нийтлэгдсэн байна. Тэрхүү өгүүлэлд: Рес-хэмээх үг бол хэрэг гэсэн утгатай, Публика гэдэг нь ард гэсэн санаатай хуучин латин үг. Эл хоёр үг хоршихоороо Ардын Бүгд Найрамдах төр хэмээх утгыг илэрхийлнэ. Бүх улсын ард өөрийн дотроос чадалтай хүмүүсийг сонгож, Засгийн газар байгуулан, улсын дээд эрхийг өгнө. Сонгогчид нь үе улиран улсын эрх барихгүй, тогтоосон болзолтойгоор 3-5 жил сууж, сонгуулиар солигдоно. Бүгд Найрамдах захиргаа маш эртний үүсгэлтэй. Хамгийн түрүүн Бүгд Найрамдах захиргаа Финики, Грек, Итали зэрэг газруудад жинхэнээр тогтож байсан, хаант засаг олон жил тогтнон баян нэртэй хэдхэн цөөн хүн дураар ашилж, ардыг хохируулж байсан Францад бүгд найрамдах захиргаа тогтоох гэж зуун жил тэмцэн явагдсан, олон оронд ийм тэмцэл явагдаж байгаа бөгөөд Америкт бүгд найрамдах засаг тогтноод бусдаас илүү урагшилж хөгжиж байна (8) гэж бичжээ. Цааш нь бичихдээ Бүгд Найрамдах төр боловсронгуй улсад тохиромжтой, улсын дээд зэргийн сонгогдсон Ерөнхийлөгч барина. Их Ерөнхийлөгчийг бүх ардын төлөөлөгчдийн цуглаан хэмжээлэн тогтооно. "...Улсын хуралд олон намын ба угсаатны хэдэн зуун төлөөлөгчид цугларч, улсад ямар ямар зүйл тустай болохыг тус тусдаа санал гарган хэлмэгц олноор хэлэлцэж, олонхийн тогтоосны ёсоор хүлээх дүрэм..." (9) болгон гаргана. "Улсын хуралд цугларсан ардын төлөөлөгчид зохих тэргүүн сайдын хийсэн ажлын зэргийг авч үзээд, ардад тохирохгүй хортой зүйл болбоос тухай дор осолдсон тэргүүн сайдыг албанаас гаргаж, түүний оронд өөр хүнийг таливмой" (8) гэх зэргээр бичжээ. Уг өгүүлэлд Бүгд Найрамдах засгийн үүсэл гарал, сонгож байгуулах зарчим, хугацаа, парламент байгуулахын учир холбогдол зэргийг нэлээд тод томруун тусгажээ.

1918, 1919 оны заагаар Хүрээний болон Консулын хоёр бүлэг байгуулагдаж, хувьсгалчид бүр эхнээсээ "шашин үндсээ бодох" бодлого явуулж шинээр тогтоох засаг төрийн хэлбэр, шинж чанарын тухай асуудалд гол анхаарлаа төвлөрүүлэх болов. Тэд бүр 1920 оны эхээр Сүй Шүчжэний хаалган дээр наалдуулсан ухуулах бичигтээ: "...ер угсааг дагаж, хошууны засаг залгамжлуулахыг нэг мөсөн устгаж, одоогийн эрдэм ухаангүй засгийг халж, дэлхий дахины олон гадаад улсын адилаар сонгож байгуулах засгийг явуулна" (9,9) гэжээ. Энд хөрөнгөтний ардчилал, хөрөнгөтний Бүгд Найрамдах засаг, сонгож байгуулах төрийн тогтолцооны үзэл санаа дэвшүүлсэн байна. Учир нь "дэлхий дахины олон гадаад улсын адилаар сонгож байгуулах засаг" тогтооно гэдэг нь ганц ЗОУ-ыг бус, өрнөдийн орнууд дахь БНУ-ын нэг адил сонгуулийн ардчилалын үндсэн дээр засгийн хэргийг явуулах тухай санааг шууд илэрхийлжээ.

1920 оны VI сарын 25-нд хоёр бүлгийн хамтарсан хурлаар "Монгол Ардын Нам" хэмээх хувьсгалт байгууллагыг байгуулаад, батлан томилуулсан "Намын хүмүүсийн дагаж явах тангарагийн бичиг"-т "...дотоод засгийг үнэн сэтгэлээр сайжруулан засамжилж, ядуу дорд ард түмний тусыг туйлаар бодох ба өөрийн дотоод эрхийг өнө үүрд сахиж, дарлах дарлагдахын зовлонгүй аж төрөхийг чухал болгоно" (10,7) гэсэн үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд тогтоох төр нь ангийн шинж чанараараа ардын эрхт төр байх болно хэмээн тодотгосон хэрэг юм.

Монголын хувьсгалчдын төрийн тухай мэдлэг, үзэл санаа өсөн төлөвшихийн хэрээр төрийн тухай үзэл баримтлалаа улам нарийвчлан боловсруулах болов. Эрхүү хотноо очсон Монголын хувьсгалчид 1920 оны XI сарын 10-нд Коминтерний Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын Монгол-Төвдийн хэлтэст явуулсан бичигтээ: "...бидний ардын намын хүн нар Орос улсын их тусыг ардын намын нэрээр хүлээн аваад сонгох тушаалтны...цэрэг хүчийг хэрэглэн автономийг олоод, хутагтыг хэмжээтэй эрхт эзэнд өргөж, тэдний хүч чадлаар угсаа залгамжлах ноёдын их баргийг эвдүүлэх арга хэрэглэн... баахан засрах төлөвийг олж мэдэл нээгдэх байдлыг үзмэгц нэг хоёр жилийн дотор дахин хувьсаж, цөөхөн эрхтнийг эвдэнэ" (9,11) хэмээн төрийн тухай чиг баримтлалаа тодорхойлжээ. Энд 1) "сонгох тушаалтан" гэж бичиг эрдэм сурсан хүмүүсээс сонгон шилж, хошуу туслагч, захирагч, мэйрэн, залан зэрэг албанд хүчин зүтгэж байсан хүмүүсийг хэлсэн бололтой. 2) "Автономийг олох" гэдэг нь зөвхөн өөртөө засах эрхийг сэргээх төдий утгаар биш, харин олон түмэнд ойлгомжтой нийтлэг

томъёолол хэрэглэж, хувьсгалд нийгмийн янз бүрийн анги, давхрааг татан оролцуулах тактикийн бодлогыг илэрхийлсэн, 3) Тус орон дахь хүчний харьцаа байрлал, Богд гэгээний нэр, нөлөө үлэмж байсан өвөрмөгц онцлогийг харгалзан, хэлбэрийн хувьд хэмжээт цаазат хаант засаг тогтоох зорилт тавьсан. Гэхдээ "угсаа залгамжлах ноёдын их баргийг эвдүүлэх арга хэрэглэн" гэдгийн цаана сонгуульт байгууллын тухай үзэл санаа агуулагдах аж. 4) Хувьсгалын дараа нийгэм улс төр, эдийн засгийн олон талт арга хэмжээ авч, гадаад, дотоод байдал бэхжмэгц хамжлагат ёсыг бүрэн халж, сонгуулийн үндсэн дээр **Ардын Бүгд Найрамдах Улсыг тунхаглах үндсэн чиг шугамаа томъёолжээ**. Шинээр тогтоох төрийн тухай үзэл баримтлал боловсруулахад 1920 оны XI сарын 10-нд анх гарсан "Монголын үнэн" сонин нэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Тухайлбал, тус сонинд нийтлэгдсэн "Монгол улсын боловсрон мандах явдал тус", "Монгол улсад ямар засаг хэрэгтэй вэ?", "Монгол улсын шинэ ардын засаг байгуулах үндсэн журам", "Монгол улсын шинэ ард олны эрхт төвийн ба нутгийн засгийн янз төлөвийн тус" зэрэг өгүүлүүдэд шинээр тогтоох төрийн мөн чанар, түүний байгууллагуудыг байгуулах үндсэн зарчмыг тодорхойлсон байна. "Монголын шинэ ардын засаг байгуулах үндсэн журам" хэмээх өгүүлэлд хөрөнгөтний ардчилсан төр бол цөөн тооны мөлжигчдийн төр байдаг гэж шүүмжлээд "...шинэ мандах өөртөө эзэрхэх Монгол улсын засаг болбаас тогтмол хугацаатайгаар ард олны сонгосон хэдэн хүмүүс зөвлөлдөн барих онц засаг агаад, ард олноор шалгагдаж, хийсэн үйлдвэрийнхээ (үйл ажлынхаа. Зох) хариуг биесээр даах хуультайгаар зохион байгуулмуй" (9,39) хэмээсэн нь **энэ засаг бол 1. ард олны засаг. 2. ард түмэнд эрх чөлөө олгож, шинэ амьдралыг байгуулах засаг. 3. ард түмнээр сонгогдон байгуулагдаж, тэдний өмнө хариуцлага хүлээх засаг байна** гэсэн үзэл баримтлалд хүрсэн хэрэг байлаа. Түүнчлэн "Монгол улсын шинэ , ард олны эрхт, төвийн ба нутгийн засгийн янз төлөвийн тус" гэсэн өгүүлэлд шинэ тулгар улсын төв, орон нутгийн засаг захиргааг байгуулах үндсэн журмыг боловсруулаад, төрийн эдгээр олон шатны байгууллагын үндэс нь ардын хурал хэмээн үзсэн байна.

"Монгол улсын шинэ, ард олны эрхт, төвийн ба нутгийн засгийн янз төлөвийн тус" хэмээх өгүүлэлд: "... монгол улсын шинээр байгуулах ардын эрхт хөдөө нутгийн ба төвийн засгийн янз төлөв, ямар ахуйг" (10,55) товч тодорхой өгүүлсэн байна. Тухайлбал, төрийн төв болон орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, сонгох сонгогдох зарчмыг өмнөхөөс илүү өргөн хүрээтэй гарган тавьжээ. Орон нутгийн засаг захиргааг байгуулахдаа: 1. Сумын ардын зөвлөл хэмээх чуулган нь сумын яамыг 3 хүнээр сонгон байгуулж, мөн "өөрсдийн дундаас олон цөөний хирээр хэдэн итгэлтэй чадамгай сайн хүн нарыг хошууны хуралдаанд суух төлөөлөгч болгон" (10,57) сонгох, 2. Сум бүрийн төлөөлөгчид хамтарч хошууны зөвлөл хэмээх чуулганыг хийж, 3-5 хүнтэй хошууны яамыг байгуулан, "өөрсөд дундаас хошуу зоны олон цөөний хирээр нэгэн хэдэн мэргэн сайн хүн нарыг аймгийн зөвлөлд суулгах төлөөлөгч болгон" (10,57) сонгох, 3. Хошуудын төлөөлөгчид хамтарч хуралдан, аймгийн төлөөлөгчдийн зөвлөлийг байгуулж, 3-5 хүнтэй аймгийн яамыг бүрэлдүүлэх, 4. Улс төрийн дээд эрх барих газар нь Монгол улсын төлөөлөгчдийн их зөвлөл хэмээх хуралдаан гээд "Хошууны төлөөлөгчдийн зөвлөл өөрсөд дундаас буюу ардын дундаас итгэлтэй мэргэн сайн хүмүүсийг сонгон олж, тэдгээр сонгогдсон хүмүүс нь Гадаад Монголын нийслэл Да Хүрээний газраа хуралдаж, улсын төлөөлөгчдийн их зөвлөл болмуй" (10,58) гэжээ. Энд Монгол улсын төлөөлөгчдийн их зөвлөлд төлөөлөгч сонгохдоо аймгаас бус хошууны төлөөлөгчийн зөвлөлөөс сонгохоор заасан нь аль болох сонгогч олон түмэн рүү ойртуулахыг эрмэлзэж, зарим талаар дундатчилах хандлагатай байжээ.

Эл өгүүлэлд төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагын ялгаа зааг, гүйцэтгэх дээд байгууллагыг сонгож байгуулах зарчмыг тодорхойлжээ. Тухайлбал, "энэхүү улсын төлөөлөгчдийн их зөвлөл нь гадаад Монгол улсын хамаг бүх хэргүүдийг цөмөөр мэдэж шийтгэх, хууль журам зохион гаргах хэргүүдээ бүтээгч яамуудыг ёсоор бүтээсэн эсэхийг шалгаж засаж залруулах, улсын алба татвар тэргүүтнийг хэр хэмжээ зэргийг тогтоох тэр мэт жич улсын хэрэг бүгдийг

мэдэн шийтгэж баймуй" (10,58) гэж заагаад "Улсын төлөөлөгчдийн их зөвлөл нь өөрсөд дундаас буюу улсын дундаас үлэмж эрдэмтэй билэг оюун сайтай агаад улсдаа үнэн итгэлтэй хүн нарыг хэрэглэгдэх зэргээр 5 буюу 7 буюу эс бөгөөс 9-ыг сонгон тавьж, улсын Сайд нарын Зөвлөл хэмээх яам байгуулмуй" (10,58) гэжээ. Энэ нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага - Засгийн газар юм. Засгийн газрын үүргийг "Энэхүү улсын Сайд нарын Зөвлөл нь улсын төлөөлөгчдийн их зөвлөлийн тогтоосон шийтгэсэн хамаг улсын хэрэг үйлсийг ёсоор үйлдсэн эсэхийг улсын төлөөлөгчдийн их зөвлөлөөр шалгагдаж байх бөгөөд өөрсдийн үйлдсэн бүтээсэн хэрэг бүгдээн тус их Зөвлөлд айлтган толилуулж баймуй" (10,58) хэмээх заасан байна.

Энэхүү өгүүлэлд Төрийн болон Засгийн газрын тэргүүнийг сонгох бөгөөд угсаа залгамжлахгүй гэдгийг тодотгон тэмдэглэжээ. Үүнд: "Улсын их зөвлөл нь Сайд нарын Зөвлөлийн хүмүүсийг сонгохоос гадна улсын тэргүүлэгчийг сонгож суулгамуй. Улсын сонгомол тэргүүлэгчийн орыг түүний хөвгүүн буюу шадар төрсөн нь залгамжлан суух бус...бүгд Монгол улсын төлөөлөгчдийн их Зөвлөлөөр сонгогдож суулгагдах амуй" (10,58) гэжээ.

1921 оны III сард баталсан МАН-ын анхны мөрийн хөтөлбөрт" ...хамгийн урьд засгийн эрх мэдлийг ард түмэнд шилжүүлэн авч ардын хуралт сонгуулийг эрхэлсэн улс (гүрэн) байгуулбал зохино" (11,16) гэж заасан нь шинээр тогтоох **төрийн тухай хувьсгалчдын үзэл баримтлалын хураангуй илэрхийлэл юм.** Энд нэг зүйл тэмдэглэхэд, монголын хувьсгалчдын их зонхи шинээр тогтоох төрийн тухай асуудлыг үндэсний ардчилсан үзлийн үүднээс авч үзэж байсан бөгөөд харин Коминтерн, большевикуудтай нягт хамтран ажиллах тусам төрийн тухайд аажим аажмаар ангич байр суурь луу шилжих хандлагатай болж байв.

1921 оны III сарын 13-нд МАН, ардын журамт цэрэг, хил орчмын зарим аймаг, хошуу, шавийн төлөөлөгчдийн хурал болж, "Монгол ардын засгийн хэргийг бүгд түр ерөнхийлөн захирах газар" хэмээх Ардын түүх Засгийн газрыг байгуулжээ. Уг тогтоолд: "Түр зуурын Засгийн газарт тулган даалгах нь ... манай ардын төлөөлөгчдийн их хурлыг зарлан хуралдуулж, үүрд байх засгийг олж, улсын үндсэн цааз дүрмийг тогтоолгосугай" (9,40) гэжээ. Ардын түр Засгийн газрыг долоон хүний бүрэлдэхүүнтэй сонгон байгуулж, тэргүүлэгч даргаар Д.Чагдаржавыг, гишүүн түшмэлээр Д.Сүхбаатарыг, гишүүдэд Билэгсайхан, Сумъяа, Чойбалсан нарыг баталж, нэг гишүүнийг Урианхайн хязгаараас сонгохоор тогтжээ. Ийнхүү үндэсний ардчилсан хувьсгалын удирдах төв – АТЗГ -ыг ардын хурлаар сонгож байгуулсан нь шинэ тогтоох төрийн үзэл баримтлалаа амьдралд хэрэгжүүлж эхэлсний баталгаа юм.

Сонгууль нь иргэд сонгох, сонгогдох улс төрийн эрхээ хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгохын хувьд бүхэл бүтэн тогтолцоо болон төлөвшсөн үе нь 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалт, түүний цаашдын өрнөлттэй холбоотой байлаа. МАН төрийн эрх баригч нам болмогц анхныхаа мөрийн хөтөлбөртөө дэвшүүлсэн сонгуулийн тогтолцооны тухай үзэл санаагаа амьдралд алхам алхмаар хэрэгжүүлж эхэлжээ. Монгол оронд хэдийгээр төрийн хэлбэрийн хувьд хэмжээт цаазат хаант засаг тогтсон боловч, бөгөөд харин монголын удирдагчдын их зонхи нь эл засгийг Монголын төрийн хөгжлийн цаашдын гол төрх гэж үзэж байжээ. Тэд Монгол улсын Англи, Япон мэт хэмжээт эрхт хаантай, парламентат ёсны Бүгд Найрамдах улс байхаар төсөөлж байлаа. Гэвч нөгөө хэсэг нь завсрын, шилжилтийн шат гэж үзэж, цаашид хаангүй Бүгд Найрамдах Засгийн хэлбэрийг сонгоно гэж ойлгож байв.

1921 оны XI сарын 1-ний өдөр Ардын Засгийн газрын тогтоолоор "Тангарагийн гэрээ" хэмээх дүрмийг баталж, түүнд Богд хаан болон Ардын Засгийн газрын тус тусын эрх хэмжээ, тэдний хоорондын харилцааны зарчмыг тодорхойлжээ. Эл дүрмээр Богд хаан төрийн тэргүүний хувьд улс төрийн хэрэг явдалд ямар нэг хэмжээгээр хамаатай байсан боловч, төрийн хэрэгт оролцох эрхийг их хэмжээгээр хязгаарласан байна. "Тангарагийн гэрээ"-нд сонгуулийн тухай ямар нэгэн заалт байхгүй боловч, VIII зүйлд: "Энэхүү дүрмийг тус улсын их хуралдаан хуралдахын янар хүчин төгөлдөр явуулбаас зохино" (9,115) гэж заасан нь яваандаа сонгуулийн шинэ тогтолцоог бий болгоно гэсэн

санааг илэрхийлсэн хэрэг юм. "Тангарагийн гэрээ"-г "иргэний гэрээ хэлэлцээ" төдий утгаар ойлгож болохгүй, төрийн хэрэгт Богд хааны оролцох эрхийг хязгаарлан тогтоох, Ардын засгийн бүрэн эрхийг баталгаажуулсан Үндсэн хуулийн шинжтэй акт хэмээн үзвэл зохилтой.

Ардын засгийн газар төлөөлөгчдийн байгууллагын тогтолцоо бүрэлдүүлэх ажлыг алхам алхмаар хийж эхэлсэн байна. Түүний тод илрэл бол 1921 оны VIII сард олон хошуудын ард, түшмэд, ноёд, лам нар, МАН-ын төлөөлөгчид оролцсон нэгэн хуралдаан болж, Улсын Их Хурлыг хуралдуулахын янар зөвлөх эрх бүхий Улсын түр цагийн хурлыг (УТЦХ) байгуулахаар тогтжээ. Чингээд 1921 оны IX сарын 20-ны өдөр Ардын засгийн газар УТЦХ-ын дүрмийг баталжээ. Энэ дүрмийн 1-4 дүгээр зүйлд тус хуралд төлөөлөгч сонгох журмыг заасан байна. Дүрэм ёсоор УТЦХ-д төрийн яамдын эрхэлсэн түшмэл, дэд сайд, тэргүүн сайдууд албан тушаалынхаа эрэмбээр оролцож хуралдах ба харин дөрвөн аймаг, шавь таваас тус бүр 6 хүн, үүний дотор ард 5, ноён 1, Намын Төв Хорооноос 1, ХЗЭ-ээс 3, Сурган боловсруулах хэлтсээс 1, Цэргийн хороо бүрээс 1 төлөөлөгч сонгон ирүүлэхийг заав. Чингэхдээ сонгуулийг ямар журмаар яаж явуулахыг заагаагүй байна. УТЦХ-д төлөөлөгч сонгоход эгэл ардууд улс төрийн амьдралд оролцох мэдлэг, дадал суугаагүй байсан учраас төдийлөн өрсөлдөөнтэй болж чадаагүй байна.

Дүрэм ёсоор УТЦХ ард, цэрэг, түшмэл, ноёд нийт 56 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, 1921 оны X сарын 28-ны анхдугаар хуралдаанаа хийжээ. Эл хуралдаанаар лам нарын сахилга журам, яам, газруудын бичиг хэргийн зардал хэмнэх, цэргийн дүрэм, журмыг боловсронгуй болгохтой холбоотой асуудлыг хэлэлцэн, зохих арга хэмжээ авахыг АЗГ-т санал болгосон байна. Улсын түр цагийн хурал АЗГ-аас ирүүлсэн болон өөрсдийн санаачилсан асуудлыг хэлэлцэж байжээ. Тус хурал оршин тогтнох хугацаандаа 60 орчим удаа хуралдаж, түүхэн үүргээ зохих ёсоор биелүүлсэн юм. УТЦХ нь монголын нийгмийн янз бүрийн анги, давхрааны бодол санаа, хүсэл зоригийг илэрхийлсэн ардчилал, үндэсний нэгдлийн шинжтэй байгууллага байсан билээ. Уг хурал Улсын Их Хурлыг хуралдуулах бэлтгэл хангах түүхэн үүргээ гүйцэтгээд, 1923 оны эцсээр тарсан аж.

1922 оны IX сарын 20-нд Засгийн газрын төлөөлөгчдийн дүрэм баталжээ. Эл дүрмийн гуравдугаар зүйлд: "Төлөөлөгчдийг сонгон томилоход засгийн бодлогыг гүйцэдээр ухуулан нэвтрүүлж чадах, уул газар орны эв суртлыг боловсон мэдэх, олны санаанд үнэхээр нийлүүлэн чадах, эрдэм үзэл тэнцэх хүмүүсийг эрхлэх газрын хуралд хэлэлцэн сонгон томилно. Төлөөлөгч суулгавал зохих газрын олон нийтээр уул харъяат газар оронд төлөөлөгч болж болох хүнийг урьдаас батлан гарчих нь болбоос мөн ч хянан сонгоход оруулж болно" (12,42) гэж заажээ. Энэ дүрэмд Засгийн газрын төлөөлөгчөөр ямар хүнийг сонгох вэ? гэдэг шалгуурыг тов тодорхой зааж өгчээ.

Ардын засгийн газар 1921 оны I сарын 5-ны өдрийн хуралдаанаараа "Монгол улсын нутгийн захиргааны дүрэм"-ийг баталжээ. Энэ дүрмээр сонгуулийн үндсэн дээр төрийн болон орон нутгийн нэгдмэл тогтолцоо бий болгох зарчим, журмыг тогтоож өгчээ. Дүрэм ёсоор арван гэр, баг, сум, хошуу, аймаг, улс гэсэн сонгуулийн олон шаттай тогтолцоо байхаар зааж, зохих шатны хурлуудад төлөөлөгч сонгох хэмжээг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд: Арван гэр бүрээс нэг төлөөлөгч сонгож, арван гэрийн хурал байгуулах, арван гэр бүрээс хоёр төлөөлөгч сонгож, багийн хурал байгуулах (баг 50 өрхтэй) арван гэр бүрээс нэг төлөөлөгч сонгож, сумын хурал байгуулах (сум 150 өрхтэй) дөрвөөс дээш сумтай хошуудад тус бүрээс таван төлөөлөгч сонгож, хошууны хурал байгуулахаар заажээ. Чингэхлээр арван гэр, баг, сум, хошуу, аймагт төрийн эрх барих байгууллага нь хөдөлмөрчдийн төлөөлөгчдийн хурлууд болжээ.

Дүрмийн гуравдугаар зүйлд: "Улсын ба аймаг, хошуу, сум, баг, арван гэрийн дарга хүртэл аливаа албан тушаалтан буюу тус бүрийн хурлын төлөөлөгчдийг сонгоход цөм эрхбиш ард олны зовлон зүдүүрийг нэвтэрхий мэдэх олны тусыг бодох бөгөөд цэвэр, шударга...хүнийг сонговол зохино" (12,46-47) гэж заасан нь төр, түмнээ гэсэн сэтгэлтэй, чин шударгуу хүнийг олж сонгохыг заасан хэрэг юм. Харин дүрмийн дөрөвдүгээр зүйлд: "урьдахь зүйлд дурдсан бүхий л тушаалтан ба төлөөлөгчдийг

сонгоход харъяат хурлын гишүүдэд ноёд баяд ба ураг төрлийг нүүрчлэх ба эзэрхэг харгисын сүрээс айх ба эд ашигт шунах зэргээр зусарч, бялдууч, ховдог авилгалч, хааш яаш хүнийг сонгох зэргийн гэм өдүүлэх бол сонгосон, сонгогдсон хоёр этгээдийг цөм улсын цаазыг зориудаар зөрчсөн гэж үзэж, хууль ёсоор хүндэд яллан уул тушаалын орыг өөр сонгуулна" (12,47) хэмээн сонгогч, сонгогчдын төрийн өмнө хүлээх хариуцлагыг тодорхойлжээ. Эдгээр зүйлийн аль алинд нь иргэдийн үндсэн эрх-төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрх зүйн үндсийг бүрдүүлэхийн хамт төрийн бүх шатны байгууллагад улс Монголоон гэсэн нэгэн үзүүрт сэтгэлтэй, чадварлаг хүмүүсийг сонгохоор заажээ.

1923-1924 онуудад баталсан "Их шавийн нутгийн захиргааны дүрэм", "Дүрвэд хоёр аймгийн захиргааны дүрэм", "Ховдийн харъяат газрын дүрэм", "Дарьгангын нутгийн захиргааны дүрэм", "Хотын түр захиргааны дүрэм" зэрэгт тэдгээр газар сонгууль явуулах журмыг нарийсган зааж өгсөн байна. Жишээлбэл, "Их шавийн захиргааны дүрэм"-ийн нэгдүгээр зүйлд: "Их шавь бол Олноо өргөгдсөний арван гуравдугаар оны хоёр сарын орчим шинийн таван бөгөөд аргын улирлын гурван сарын хоёрны өдөр тогтоон зарласан Монгол улсын нутгийн захиргааны дүрмийн нэгдүгээр зүйлийг журамлан арван гэрээс баг, отог, харъяат шавийн яамны газар хүртэл тус тус ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан хурал байгуулж, элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхийн саналаар таслан тогтоож, ардын эрхийг эрхэмлэн гүйцэтгэвэл зохино" (12,66) гэж заасан байна".

Орон нутгийн засаг захиргааг ардчилсан үндсэн дээр халж өөрчлөх ажил 1923 оны эцсээс 1924 оны намар хүртэл үргэлжилжээ. "Нутгийн захиргааны дүрэм" ёсоор хамгийн түрүүнд арван гэрийн хурлууд болов. Дараа нь баг, сумын хурал шат дараалан болж, баг, сумын дарга болон хошууны хурлын төлөөлөгчдийг сонгож, доод шатны хурлуудын хэлэлцэж тогтоосон хэргүүдийг батлан, цаашид тавих зорилтоо тодорхойлсон хэргүүдийг батлан, цаашид тавих зорилтоо тодорхойлсон байна. Ийм маягаар хошуу, шавийн хурал болж, аймгийн хуралд очих төлөөлөгчийг сонгожээ. Хошуудын хурлын дараа 1924 оны IX сарын эхээр Халх дөрвөн аймаг, Их Шавийн их хурал тус тус болов. Тус бүр 30-50 төлөөлөгчид сонгогдон оролцсон тэдгээр их хурал нутгийн захиргааны дүрмийн үндсэн дээр аймаг орны улс төр, аж ахуй, зохион байгуулалтын асуудлыг нэлээд өргөн ардчиллын дагуу хэлэлцсэн байна. Аймгийн хурлууд нь аймгийн чуулган дарга, дэд дарга, эрхэлсэн түшмэл ба захирах тушаах, зарга шийтгэх, сангийн хэлтсийн эрхэлсэн түшмэдийг орлогчдын хамт, мөн Улсын анхдугаар хуралд одох төлөөлөгчдийг нууц санал хураалтаар сонгон, аймгийн яамдыг байгуулжээ. Сонгуулийн үр дүнд орон нутгийн засаг захиргааны байгууллагын удирдлагад байгаа засаг ноёдын 90 гаруй хувь нь ардын төлөөлөгчөөр солигдсон байна. Харин хуучныг халах нэрийдлээр зарим газар хэт хувьсгалчирхах хандлага гарч байжээ.

1924 онд Халх дөрвөн аймаг, Их шавь, Хөвсгөлийн урианхай ба Ховдын тариачин хошуу эдгээр долоон газарт арван гэр 9456, баг 1833, сум 540, отог 83, хошуу 106 байсан бөгөөд тэдгээрт тус бүр хурал байгуулснаар бүгд 11960 хурал байгуулагдаж, ойролцоогоор бодоход тэдгээр хуралд нийт хүн амын 20 орчим хувь нь шууд оролцож байжээ. (13, 116-117). Ийнхүү эрт үеэс 1924 он хүртлэх Монгол төрийн сонгох уламжлалыг авч үзвэл дараах гол дүгнэлт гарч байна. Үүнд:

1. Монголын эртний улсуудаас эхлэн дундат үед сонгуулийн тогтолцоо байгаагүй боловч, төрийн албанд тохоон томилох хүнийг шилж сонгох, хааныг өргөмжлөн сонгох зэрэг сонгуулийн зарим бүрдэл байжээ. Их хуралдай, Сэцдийн зөвлөл зэрэгт шилэгдэн орж буй хүмүүс ямар нэг хэмжээгээр ард олны төлөөллийн шинжтэй байсныг шууд үгүйсгэх аргагүй юм.

2. Олноо өргөгдсөн Монгол улсын үеэс сонгуулийг эрхэлсэн гүрэн байгуулах тухай үзэл санааны эхлэл тавигдаж, 1918-1919 оны заагаар үүссэн улс төрийн зохион байгуулалттай бүлэглэлүүд, улмаар Монгол Ардын Нам сонгуулийн үндсэн дээр Бүгд Найрамдах засгийг байгуулах үзэл баримтлалыг боловсруулжээ.

3. 1921 оны үндэсний хувьсгалын дараа Монголын төрийн сонгуулийн тогтолцоо нь төрийн дээд удирдлага солигддог, иргэд сонгох, сонгогдох эрхээ эдэлдэг ардчилсан

арга хэрэгслийн хувьд төлөвшиж эхэлжээ. 1923 онд батлагдсан "Монгол улсын нутгийн захиргааны дүрэм" бол сонгуулийн тогтолцоо жинхэнэ утгаар нь бүрэлдүүлж, цаашид гүнзгийрэн төлөвших эрх зүйн үндсийг тавьж өгсөн байна.

4. Төрийг удирдах хэрэгт олон түмнийг өргөнөөр оролцуулах хэлбэр-арван гэр, баг, сум, хошуу, аймаг, шавийн төлөөлөгчдийн хурал шат дараалан байгуулагдсан нь ардын төлөөлөгчдийн байгууллагын нэгдмэл тогтолцоо төлөвшин хөгжих үндсийг бүрдүүлжээ.

"About the elective traditions in Mongolian statehood"

Summary

By J. Boldbaatar, L. Ariunaa

There election history traditions before republican establishment /common wealth/.

1. The ancient state election rules of Mongol states /B.C/-209 to the XII century.
2. The election rules of the Great Mongol /State/ empire.
3. The political elections rules in Fradmentation times.
4. The elections rules in the Manchu oppression times.
5. The elections rules in Bogdo khan's Mongol state.
6. The premature condition before republican election system /1919-1924/.

Ишлэл, зүүлт

1. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь УБ. 1966.
2. Монголын нууц товчоо УБ. 1976.
3. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. УБ.1995.
4. "Шинэ толь" 1913. №1.
5. Монголын сонин бичиг. 1917. №226.
6. Монголын сонин бичиг. 1917. №246.
7. Д.Дашжамц. Монгол дахь дэвшилт ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд. (XIX-XX зууны зааг) УБ. (Дам иш татав)
8. Нийслэл Хүрээний сонин бичиг. 1917. №63.
9. Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдох баримт бичгүүд (1920-1940 он) I дэвтэр УБ. 1966.
10. "Монголын үнэн" сонин. (Сонинд нийтлэгдсэн өгүүлэл, мэдээний эмхтгэл) УБ. 1971.
11. МАХН-ын Их, Бага хурал, Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр. I хэсэг. УБ. 1956.
12. Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. УБ.1954.
13. М.Санждорж. Ардын төрийн түүх. УБ. 1974.